

## **МБСХ-Д ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ХАСАХ ЖУРАМ**

### **Монголын Бүжгийн Спортын Холбоо**

Монголын Бүжгийн Спортын Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрөн дэмжигч хувь хүн, байгууллага бүр МБСХ-ны гишүүн байж болно.

#### **1. Элсэлт**

1.1. МБСХ-нд элсэхийг хүссэн байгууллага дараах материалыг бүрдүүлж МБСХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад өгнө:

- Тухайн байгууллагын Тэргүүний МБСХ-нд элсэхийг хүссэн өргөдөл. Өргөдөлд: “Бид МБСХ-ны бүхий л дүрэм, журам, МБСХ-ны Тэргүүлэгчидийн хурал болон Ерөнхий чуулганаас гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрнө” гэсэн үгс байна.
- Байгууллагын дүрэм
- Байгууллагын байрлах хаяг, утас
- Байгууллагын удирдлагын нэрс, хаяг, утас, и-мэйл, эрхэлдэг ажил г.м
- МБСХ-нд элсэлтийн татвар болох 30000₮

Тэргүүлэгчид өргөдөл гаргагчаас шаардлагатай нэмэлт мэдээлэл гаргахыг шаардах эрхтэй.

1.2. Элсэлтийн асуудлыг Тэргүүлэгчидийн хурлаар шийдвэрлэнэ. Өргөдлийг хэрэгсэхгүй болгох шалтгаан байвал татгалзах эрхтэй. Хэрэв татгалзсан шийд гарвал Ерөнхий нарийн бичгийн дарга өргөдөл гаргагчид нэн даруй танилцуулна.

1.3. Тэргүүлэгчидийн хурлаас өргөдлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд МБСХ-нд элссэнд тооцно.

#### **2. Гишүүний үүрэг**

2.1. МБСХ-ны бүхий л дүрэм, журам, МБСХ-ны Тэргүүлэгчидийн хурлын болон Ерөнхий чуулганаас гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх.

2.2. МБСХ-ноос зохион байгуулж буй тэмцээн, сургалт, аливаа арга хэмжээнүүдэд гишүүдээ идэвхитэй оролцуулах.

2.3. МБСХ-ны Санхүүгийн журмын дагуу татвар төлнө. Тухайн байгууллага нь жил бүрийн татвараа төлснөөр гишүүний эрхийн хугацаагаа сунгаж, Бүжгийн спортын сургалт, үйлчилгээ явуулах, тэмцээн зохион байгуулах, МБСХ болон IDSF-аас зохиож буй тэмцээн, сургалт-семинар бусад арга хэмжээнд оролцох эрхтэй болно.

#### **3. Гишүүний эрх**

3.1. Ерөнхий чуулганд таслах эрхтэйгээр оролцох.

3.2. МБСХ-ны Тэргүүлэгчдэд нэрээ дэвшүүлэх.

3.3. МБСХ болон IDSF-аас зохион байгуулж буй аливаа тэмцээн уралдаанд оролцох.

3.4. Бүжгийн спортын чиглэлээр зэрэг, цол авах.

3.5. МБСХ болон IDSF-ын санхүүгийн журамд заасны дагуу тодорхой төлбөр төлж МБСХ, IDSF-ын тэмцээнүүдийг зохион байгуулах эрхийг авах.

3.6. МБСХ-ны телевизийн нэвтрүүлэг, вэб хуудсаар албан ёсоор сурталчлуулах.

#### **4. Гишүүдэд тавигдах үндсэн шаардлага**

4.1. Сургалт дасгалжуулалтын материаллаг бааз (заал, толь, хөгжмийн аппаратур, хувцас г.м.)-тай байх.

4.2. Бэлтгэл, сургуулилтын заал танхим нь талбайн норм хэмжээ, эрүүл ахуйн шаардлага хангасан, гэрэлтүүлэг шаардлага хангасан байх.

4.3. Орон тооны тамирчин, дасгалжуулагчтай байх.

4.4. МБСХ-гоор батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх.

#### **5. Гишүүнчлэлийн эрхийг хасах**

5.1. Дараах тохиолдлуудад МБСХ-ны Тэргүүлэгчдийн шийдвэрээр тухайн гишүүний эрхийг хасна.

5.1.1. Тухайн байгууллагын Тэргүүлэгчид, тамирчдаас МБСХ-ны дүрэм, журам, МБСХ-ны Тэргүүлэгчдийн хурал, Ерөнхий чуулганаас гаргасан шийдвэрийг удаа дараа зөрчсөн.

5.1.2. МБСХ-ны арга хэмжээнүүдэд оролцдоггүй, эсвэл сул оролцдог.

5.1.3. Тухайн клубын тамирчид Допингийн эсрэг дүрэм зөрчсөн.

5.1.4. Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн.

5.1.5. Дүрмийн зорилгодоо нийцээгүй үйл ажиллагаа явуулсан.

5.1.6. Гишүүнчлэлийн жил бүрийн татвараа хугацаанд нь төлөөгүй.

5.1.7. Тухайн байгууллагын Тэргүүлэгчидээс үйл ажиллагаа явуулах боломжгүй болсноо мэдэгдэн гишүүнчлэлээс хасахыг хүссэн хүсэлт гаргасан.

5.2. МБСХ-ноос хассан шийдвэрийг Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн гишүүн байгууллагын удирдлагад мэдээлнэ.

## **6. Хүчин төгөлдөр болох хугацаа**

Энэхүү журмыг 2009 оны 1-р сарын 13-ний өдрийн МБСХ-ны бүх гишүүдийн хурлаар шинэчлэн баталсан бөгөөд 2009 оны 1-р сарын 14-наас эхлэн мөрдөгдөнө.